



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 13/48

Улаан-Уул

Хоршоо хөгжүүлэх сангийн талаар
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3, 3.3.1, 3.3.2, 3.3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 13 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хороог шинэчлэн 1 дүгээр хавсралтаар, хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг шинэчлэн 2 дугаар хавсралтаар, хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг 3 дугаар хавсралтаар, сангийн үйл ажиллагааны зардлыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн дээд хэмжээг 50,000,000.00 (тавин сая) хүртэл байхаар тогтоосугай.

3. Хавсралтад дурдсан чиглэлийн хүрээнд төслийг сонгон шалгаруулж, эргэн төлөлтийг сайжруулж, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д даалгасугай.


4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06/09 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА  С.ГОНГОР



Ёсчилсон 2022 оны 12 сарын 19 ны өдөр

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний
өдрийн 13/48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Хорооны дарга: Засаг даргын Тамгын газрын дарга М.Зоригт

Нарийн бичгийн дарга: Хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн
Г.Саранзаяа

Гишүүд: Хоршоо хариуцсан нягтлан бодогч Г.Очгэрэл

Банкны төлөөлөл Э.Ариунбилэг

Банкны төлөөлөл А.Мөнхцэцэг

---oOo---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний
өдрийн 13/48 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ХЯНАЛТ ТАВИХ ОРОН ТООНЫ БУС
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хяналтын зөвлөлийн дарга: Г.Нямдаваа

Нарийн бичгийн дарга: Хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн

Г.Саранзаяа

Гишүүд: Аймгийн хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн


Б.Оюунцэцэг

Төрийн сангийн мэргэжилтэн Д.Сайханцэцэг

Банкны төлөөлөл Ш.Ариунжаргал

---oOo---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний
өдрийн 13/48 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт




**ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

1. “Өлзийт” брэнд бүтээгдэхүүн бий болгох
2. Агаарын бохирдлыг бууруулах ажлын байр нэмэгдүүлэх
3. Гамшгийн нөөц бүрдүүлэх зорилгоор тэжээлийн ургамал тариалах
4. Өвлийн хүлэмж байгуулах

---oOo---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний
өдрийн 13/48 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт



САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

1. Хяналтын зардалд 1,340,000 (нэг сая гурван зуун дөчин мянга) төгрөг
2. Төсөл хэрэгжүүлж байгаа иргэдэд мэдээлэл, сургалт хийх зардалд 2,010,000 (хоёр сая арван мянга) төгрөг

---oOo---